



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2022 оны 06 сарын 28 өдөр

Дугаар 4/66

Эрдэнэт

Ээлжит хуралдаан зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дахь удаагийн сонгуулийн Ээлжит Х хуралдааныг 2022 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Эрдэнэт хотод зарлан хуралдуулж дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр тогтоосугай.

- 1.1.Аймгийн 2022 оны тодотгосон төсөв батлах тухай
- 1.2.Нэршил өөрчлөх тухай
- 1.3.Хөтөлбөр, журам батлах тухай

2.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит Х хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3.Хуралдааны бэлтгэл хангах ажлыг зохион байгуулж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд даалгасугай.

ДАРГА



Д. МӨНХБАТ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын
2022 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн
4/66 дугаар захирамжийн хавсралт



АЙМГИЙН ИТХ-ЫН ЭЭЛЖИТ Х ХУРАЛДААНЫ
БЭЛТГЭЛ ХАНГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Аймгийн ИТХ-ын Ээлжит Х хуралдааны бэлтгэл хангасан дүнг Хурлын Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх.

VII/4-нд

Аймгийн ИТХ-ын дарга Д.Мөнхбат

2. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит Х хуралдааныг зарласан тухай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид, аймгийн Засаг дарга, холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэдийг мэдээллээр хангах

VI/29-ны дотор

Ажлын алба

3. Аймгийн ИТХ-ын Ээлжит Х хуралдаанаар хэлэлцэх асуудлуудын илтгэл, танилцуулга, холбогдох тооцоо судалгааны материал, гарах шийдвэрийн төслийн хамт ажлын албанд ирүүлэх, Хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх.

VII/4, VII/7-нд

Аймгийн Засаг дарга С.Батжаргал

4. Төлөөлөгчид тойрогтоо ажиллах, хуралдаанаас гарах шийдвэрийн төсөлд тусгуулах санал асуудлыг нэгтгэж, ажлын албанд ирүүлэх.

Бэлтгэл ажлын явцад

Төлөөлөгчид

5. Төлөөлөгчид Хуралдааны техник зохион байгуулалтын бэлтгэл ажлыг хангах.

VII/7-ны дотор

Ажлын алба